БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

- ЭНГИЙН ТЭСРЭХ БОДИС
  - САВЛАСАН АНФО
  - ЗАДГАЙ АНФО
- ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС
  - САВЛАСАН ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС
  - ЗАДГАЙ ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС
- ӨДӨӨГЧ ТЭСРЭХ БОДИС
  - МЕРА ПРАЙМ
- ӨДӨӨЛТИЙН СИСТЕМ
  - МЕРА ШОКСТАР
- ИМПОРТЫН ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ БОЛОН ТЭСРЭХ БОДИС

АЯНГА | ЭНГИЙН ТЭСРЭХ БОДИС

ТОДОРХОЙЛОЛТ

Энгийн тэсрэх бодис /Аянга / -ыг АНУ-д үйлдвэрлэсэн бүрэн автомат удирдлагын систем бүхий иж бүрэн суурин тоног төхөөрөмжөөр Монгол улсын MNS4223-94 стандартын дагуу үйлдвэрлэдэг бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, усанд тэсвэргүй, үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис юм. Уг тэсрэх бодисыг задгай болон савласан гэсэн 2 төрлөөр ил болон далд уурхайд хуурай болон усгүйжүүлсэн цооног, шпурт үндсэн цэнэг болгон ашиглах бөгөөд өдөөгчийн тусламжтайгаар тэсэлгээний ажилд хэрэглэдэг.

ДАВУУ ТАЛ:

- Бүтээгдэхүүнийгдизельтүлш,чийгнийнэвчилтээс хамгаалсан полиэтилен дотортой, полипропилен гадартай давхар уутанд 25 кг-аар шуудайлсан.
- Цэнэглэгч машинаар нэг удаа 10-19 тонныг тээвэрлэн цооногийг богино хугацаанд тэсрэх бодисоор бүтээмжтэй цэнэглэдэг.
- Ашиглалтын явцад харьцангуй аюул багатай, үйлдвэрлэлийн тэсэлгээний ажилд нэн тохиромжтой, олон улсад өргөн хэрэглэгддэг, эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай тэсрэх бодис.
- Тэсрэх бодисын задгай технологи цооногт орсон хойноо тэсрэх бодис болдогоороо аюулгүй ажиллагааг бүрэн хангадаг.

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шинж чанар	Үзүүлэлтүүд
Овоолгын нягт	0.8-0.9 г/см^3
Цэнэглэлтийн нягт	1,0-1,1 г/см^3
Тэсрэлтийн дулаан	4000 кДж/кг
Хүчилтөрөгчийн тэнцэл %	+0.28
Детонацийн хурд	3500м/с

АЯНГА-Х | ЭНГИЙН ТЭСРЭХ БОДИС

ТОДОРХОЙЛОЛТ

Хүчитгэсэн энгийн тэсрэх бодис /Аянга Х/-ыг АНУ-д үйлдвэрлэсэн бүрэн автомат удирдлагын систем бүхий иж бүрэн суурин тоног төхөөрөмжөөр олон улсын стандартын дагуу үйлдвэрлэдэг бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөөгүй усанд тэсвэргүй, үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис юм. Уг тэсрэх бодисыг задгай болон савласан гэсэн 2 төрлөөр ил болон далд уурхайд усгүйжүүлсэн цооног, шпурт үндсэн цэнэг болгон ашиглах бөгөөд өдөөгчийн тусламжтайгаар тэсэлгээний ажилд хэрэглэдэг. Энэ бүтээгдэхүүн нь сувэрхэг мөхлөгт аммиакийн шүү, дизель түлш болон хөнгөн цагааны нутаг зэрэг нэмэгдлүүдээс бүрдэх тэсрэх бодис юм..

ДАВУУ ТАЛ:

- Төмрийн хүдрийн ил уурхайн болон хатуулаг өндөртэй чулуулагт хэрэглэхэд илүү тохиромжтой.
- Тэсрэх бодисын үзүүлэлт өндөртэй тул өрөмдлөг тэсэлгээний зардал бууруулах бүрэн боломжтой.
- Бүтээгдэхүүний гидэль түлш, чийгний нэвчилтээс хамгаалсан полиэтилен дотортой, полипропилен гадартай давхар уутанд 25 кг-аар шуудайлсан.
- Цэнэглэгч машинаар 10-19тонныг тээвэрлэн цооногийг богино хугацаанд тэсрэх бодисоор бүтээмжтэй цэнэглэдэг.
- Ашиглалтын явцад харьцангуй аюул багатай, үйлдвэрлэлийн тэсэлгээний ажилд нэн тохиромжтой, олон улсад өргөн хэрэглэгддэг, эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай тэсрэх бодис.
- Хүчитгэсэн энгийн тэсрэх бодисын задгай технологи цооногт орсон хойноо тэсрэх бодис болдогоороо аюулгүй ажиллагааг бүрэн хангадаг.

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шинж чанар	Үзүүлэлтүүд
Овоолгын нягт	0.8-0.9 г/см^3
Цэнэглэлтийн нягт	1,0-1,2 г/см^3
Тэсрэлтийн дулаан	4000 кДж/кг
Хүчилтөрөгчийн тэнцэл	+0.28 %
Детонацийн хурд	3500м/с

НИТРОНИТ ЗАДГАЙ ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС
ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС

ТОДОРХОЙЛОЛТ

Нитронит брэндийн задгай эмульсийн тэсрэх бодис нь ОХУ болон Австралийн хамтарсан технологи бүхий Сибирийн эрс тэс уур амьсгалтай цаг уурын нөхцөлд хэрэглэхэд зориулагдсан үйлдвэрлэлийн тэсрэх бодис юм. Энэхүү бүтээгдэхүүнийг цаг уурын бүх нөхцөл болон ямар ч төрлийн цооногт хэрэглэх бүрэн боломжтой. Уг задгай эмульсийн тэсрэх бодисыг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага болон чулуулгийн шинж чанарт тохируулан Э20, Э30, Э50, Э70, Э100 гэсэн маркын 5 төрлөөр үйлдвэрлэх боломжтой.

ДАВУУ ТАЛ

- Орчин үеийн дэвшилтэт технологиудын нэг ОХУ, Австрали улсын технологи, тоног төхөөрөмжийг ашиглан олон улсын шаардлага, стандартын дагуу дотооддоо үйлдвэрлэсэн.
- Усанд тэсвэртэй, ажлын чадвар их.
- Ил уурхайн тэсэлгээнд зориулагдсан.
- Энэхүү тэсрэх бодисын технологи нь цооногт орсон хойноо тэсрэх бодис болдогоороо аюулгүй ажиллагааг бүрэн хангадаг.
- Тэсрэх бодисын нягтыг чулуулгийн шинж чанараас хамааруулан тохируулдаг ба энэ нь төслийн үр ашигийг нэмэгдүүлдэг.
- Монголын эрс тэс цаг уурын нөхцөлд буюу +40 /-40°С хэмд хэрэглэх бүрэн боломжтой.
- Савлагааны зардал хэмнэн цэнэглэх ажиллагааг иж бүрэн автоматжуулсаанр тэсэлгээний зардлыг хэмнэнэ.
- Тусгай зориулалтын цэнэглэгч машинаар тээвэрлэн цооногийг тэсрэх бодисоор богино хугацаанд цэнэглэснээр цаг хугацаа хэмнэдэг.

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	Э-20	Э-30	Э-50	Э-70	Э-100
Тэсрэлтийн дулаан кДж/кг	3550-3600	3450-3750	3280-3370	3090-3220	2810-2900
Хүчилтөрөгчийн баланс, %	(-0,4)- (-1,6)	(-0,4)- (-2,1)	(-0,6)- (-3,4)	(-0,8)- (-4,8)	(-1,3)- (-7,0)
Нягт, г/см^3	0.9-1.05	1.0-1.2	1.05-1.25	1.05-1.25	1.05-1.25
Детонацийн хурд, км/с	4,5-4,7	4,8-4,5	4,9-5,1	4,8-5,0	4,7-4,8
Усанд тэсвэртэй байдал, хоног	тохиромжгүй		2	7 хоног	30 хоног

FORTIS ECLIPSE ЗАДГАЙ ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС

ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС

ТОДОРХОЙЛОЛТ

FORTIS ECLIPSE - задгай эмульсийн тэсрэх бодисыг ил уурхайн урвалын идэвхитэй цооногт тэсрэх бодисын шинж чанарыг хангах зорилгоор хийгдсэн тэсрэх бодис юм. Уурхайн тэсэлгээний онцлогт тохируулан тэсрэх бодисын нягтыг тохируулж болно. Устай, хуурай болон усгүйжүүлсэн цооногт хэрэглэж болно.

ДАВУУ ТАЛ

- Австрали улсын “Орика” компанийн тоног төхөөрөмж болон “НОИСЬ” технологиор олон улсын стандартын дагуу дотооддоо үйлдвэрлэсэн.
- Халуун, урвалын идвэхитэй цооног төдийгүй Монголын эрс тэс цаг уурын нөхцөл буюу +55°C/-40°C хэмд хэрэглэх бүрэн боломжтой.
- Устай, усгүйжүүлсэн, хуурай гэх мэт бүх төрлийн цооногт хэрэглэх бүрэн боломжтой.
- Тэсрэх бодисын нягтыг чулуулгийн шинж чанарт тохируулан өөрчилж, төслийн үр ашиг нэмэгдүүлэх.
- Хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагаас хамааруулан тэсрэх бодисын хүч, энергийг тохируулах боломжтой.
- Мэдрэг чанар болон цооногт байх хугацаа өндөр.
- Тусгай зориулалтын цэнэглэгч машинаар тээвэрлэн цооногийг тэсрэх бодисоор богино хугацаанд бүтээмжтэй цэнэглэдэг.

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Fortis Eclipse	Fortis Eclipse H
Нягт, гр/см3	1.10-1.25	
Хамгийн бага цооногийн диаметр, мм	90	90
Дээд цооногийн гүн, м	30	30
Цэнэглэх дээд гүн, м	25	25
Цэнэглэх цооногийн төрөл	Хуурай, нойтон, усгүйжүүлсэн	
Детонацийн хурд, км/с	3.7-6.6	4.1-6.7
Цооногт байх хугацаа	Урвалын идэвхитэй цооногт 12 цаг, урвалын идэвхигүй цооногт 21 өдөр	

ANDO-EV | САВЛАСАН ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС

ТОДОРХОЙЛОЛТ

Бялт тэслүүрт мэдрэмтгий, усанд тэсвэртэй ANDO - EV савласан эмульсийн тэсрэх бодис нь ил болон далд уурхайн тэсэлгээний ажилд зориулагдсан. ANDO - EV нь ил болон далд уурхайн бүх төрлийн шийдэлтэй цооногийг цэнэглэхэд хэрэглэгдэнэ. Олон төрлийн диаметр болон урттай, полиметилпентен хальсаар олгойлон савласан. Тэсрэх бодисын шинж чанарыг хадгалахын тул бид зөвшөөрөгдсөн агуулахад, сэрүүн, хуурай, агааржуулалт сайн газар хадгалахыг зөвлөж байна.

ДАВУУ ТАЛ

- Бялт тэслүүрт мэдрэмтгий тул тэсэлгээний зардлын хувьд хамгийн хэмнэлттэй
- Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн олон төрлийн диаметр болон орц найрлагын өргөн сонголттой.
- Усанд тэсвэртэй, хадгалах хугацаа болон детонацийн хурд өндөр.
- Хүйтэн цаг уурт зориулагдсан тул Монголын эрс тэс цаг уурын нөхцөлд хэрэглэх бүрэн боломжтой.
- CE сертификатын шаардлагыг хангасан.

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Нягт, гр/см³	1.15
Детонацийн хурд, м/с	5500
Усанд тэсвэртэй чанар	Сайн
Хадгалах хугацаа	1 жил
НҮБ-н дугаар	UN 0241
Аюултай ачааны ангиллын код	1.1D

САВЛАГАА				
Диаметр (мм)	Урт (мм)	Бүтээгдэхүүний жин (гр)	Хайрцган дахь тоо (ш)	Хайрцган дахь жин (кг)
25	354	200	112	22.4
32	433	400	55	22
38	383	500	45	22.5
65	420	1600	15	24

ANDO-V | САВЛАСАН ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС

ТОДОРХОЙЛОЛТ

Өдөөгч тэсрэх бодист мэдрэмтгий ANDO - V савласан эмульсийн тэсрэх бодис нь карьер, ил уурхай болон барилгын тэсэлгээний ажилд зориулагдсан. ANDO - V нь устай цооногт хэрэглэх нь хамгийн тохиромжтой. Олон төрлийн диаметр болон урттай, полиметилпентен хальсаар олгойлон савласан. Тэсрэх бодисын шинж чанарыг хадгалахын тул бид зөвшөөрөгдсөн агуулахад, сэрүүн, хуурай, агааржуулалт сайн газар хадгалахыг зөвлөж байна.

ДАВУУ ТАЛ

- Өдөөгчөөс мэдрэмтгий, ажлын чадвар өндөр
- Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн олон төрлийн диаметр болон орц найрлагын өргөн сонголттой.
- Усанд тэсвэртэй, хадгалах хугацаа болон детонацийн хурд өндөр.
- Хүйтэн цаг уурт зориулагдсан тул Монголын эрс тэс цаг уурын нөхцөлд хэрэглэх бүрэн боломжтой.
- CE сертификатын шаардлагыг хангасан.

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Нягт, гр/см³	1.25
Детонацийн хурд, м/с	5500
Усанд тэсвэртэй чанар	Сайн
Хадгалах хугацаа	1 жил
НҮБ-н дугаар	UN 0332
Аюултай ачааны ангиллын код	1.5D

САВЛАГАА				
Диаметр (мм)	Урт (мм)	Бүтээгдэхүүний жин (гр)	Хайрцган дахь тоо (ш)	Хайрцган дахь жин (кг)
65	386	1600	15	24
90	378	3000	8	24
120	425	6000	4	24
140	312	6000	4	24
220	253	12000	2	24

ANDOSPLIT | САВЛАСАН ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС

ТОДОРХОЙЛОЛТ

Шилэн бөмбөлгөөр хийжүүлсэн, хатууруулсан, бялт тэслүүрт мэдрэмтгий ANDOSPLIT савласан эмульсийн тэсрэх бодис нь 12 г/м ТЭН агуулсан цочир дамжуулах шижимтэй тул тэсэлгээний онцгой хэрэглээнд зориулагдсан. ANDOSPLIT нь хуваагдсан цэнэгтэй, үргэлжилсэн урттайгаар уурхайн хүрээ гаргах тэсэлгээнд тусгайлан зориулагдаж үйлдвэрлэгдсэн. Урьдчилан цуулах, зааглах тэсэлгээ, уурхайн эцсийн хана, өндөр хана гаргах, барилгын тэсэлгээ зэрэг онцгой тэсэлгээний ажилд хэрэглэнэ.

ДАВУУ ТАЛ

- Бага диаметр болон детонацийн өндөр хурдтай, цооног болон хананд бага тэсрэлтийн гэмтэл үзүүлнэ.
- Үргэлжилсэн урттай бортогон бүтээгдэхүүн тул нэг хүн цэнэглэлт хийхэд хялбар.
- CE сертификатын шаардлагыг хангасан.
- Эрс тэрс болон Монголын цаг уурын нөхцөлд хэрэглэх боломжтой.

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тодорхойлолт	Үзүүлэлтүүд
Эмульсийн нягт, гр/см³	1.15
Детонацийн хурд, (Цочир дамжуулах шижим) м/с	6200
Усанд тэсвэртэй чанар	Устай цооногт 30 хоног
Хадгалах хугацаа	1 жил
НҮБ-н дугаар	UN 0241
Аюултай ачааны ангиллын код	1.1D

САВЛАГАА

Диаметр (мм)	Тэсрэх бодисын хэмжээ, кг/м	Бүтээгдэхүүний хэмжээ, м/хайрцаг	Нийт бохир жин, кг
38	1.3	13-18	25

ӨДӨӨГЧ ТЭСРЭХ БОДИС | САВЛАСАН ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИС

ТОДОРХОЙЛОЛТ

MEPA Прайм өдөөгч нь сул мэдрэх чадвартай тэсрэх бодис болон тэсэлгээний үндсэн цэнэгийг өдөөж тэслэх зориулалттай ба уул уурхай болон зам барилгын ажилд өргөн хэрэглэгддэг тэсрэх бодис юм. MEPA Прайм өдөөгч тэсрэх бодисын үйлдвэрлэлд тэсэлгээний чанар, аюулгүй ажиллагаа болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг авч үзэн өдөөгч тэсрэх бодисын үйлдвэрлэлд өргөн хэрэглэгддэг RDX (гексоген) болон TNT (тротил) түүхий эдийг ашигладаг. Энэхүү өдөөгчийг -30°C -аас +50°C хэмд ашиглах бүрэн боломжтой.

ДАВУУ ТАЛ

- Өдөөгч тэсрэх бодис нь анхдагч өдөөгч тэсрэх бодистой харьцуулахад гадны үйлчлэлийг мэдрэх чадвар бага боловч чадал, өдөөгч хүч ихтэй, нунтаглах чадвар сайтай.
- Өдөөгч тэсрэх бодис нь детонацийн хурд өндөр ба тэсрэлтийн шинж нь бусад тэсрэх бодисоос их.
- MEPA прайм өдөөгч тэсрэх бодис нь температурын өөрчлөлт, урт хугацааны хадгалалт болон даралттай усны нөлөөгөөр чанараа алдахгүй.
- MEPA прайм өдөөгч тэсрэх бодисыг ил уурхайн чулуулгийн тэсэлгээнд ашиглана.
- Өдөөгч тэсрэх бодис нь хүчиллэг болон шүлтлэг устай, янз бүрийн тоостой нөхцөлд тэсвэртэй чанар нь ил уурхайн ямар ч нөхцөлд ашиглах боломжтой.
- 0,3 мПа даралттай, усанд 7 хоног хүртэл хугацаанд байлгасны дараа ч бүрэн тэсрэх чадвартай.
- Цооногийн буюу №8 бялт тэслүүр болон цочир дамжуулах шижмээр бүрэн өдөөгддөг.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шинж чанар	Үзүүлэлтүүд
Тэсрэх бодисын төрөл	Цутгамал тэсрэх бодис
НҮБ-н дугаар	0042
Аюултай ачааны ангилалын код	1.1D
Детонацийн хурд	7000 м/с
Нягт	1.60 гр/см3
Бортогоны өнгө	Улбар шар
Хүчинтэй хугацаа	5 жил

MERA ShockStar SURFACE | ӨДӨӨЛТИЙН СИСТЕМҮҮД

ТОДОРХОЙЛОЛТ

ShockStar SURFACE холбогчууд нь бусад хэрэгсэлд цочир дамжуулах болон цооног хоорондын удаашралыг тохируулахад ашиглагдана.
Холбогч блок нь 2 янзаар холбож хэрэглэж болдог.

Үүнд:
- Хэвийн ажиллагааны үед түгжээгүй байрлалаар ашиглана.
- Холбоход эрсдэлтэй буюу ажлын хүнд нөхцөлд түгжээг ашиглана.

Холбогч нь 8 ширхэг Нонель гуурс багтах холболтын блоктой байна.
Холбогчууд нь үндсэн цэнэгийг хамгийн бага хэмжээгээр агуулсан учир дуу чимээний түвшинг бууруулсан ба таслах, тайрах ажилбарыг хялбаршуулсан.

SHOCKSTAR SURFACE хэрэгслийг тэсэлгээнд гал өгөх зориулалтаар ашиглаж болно.
Уг бүтээгдэхүүн нь 400м, 600м, 800м-ийн урттайгаар үйлдвэрлэгддэг.
SHOCKSTAR SURFACE холбогчууд нь цочир дамжуулах шижимд өдөөлт өгөхгүй.

ДАВУУ ТАЛ

- Гуурсыг хялбар холбож болдог. Шаардлагатай үед түгжих механизм нь блоконд гуурсыг түгжихэд хэрэглэгдэнэ. 8-н гуурсыг нэг дор холбох багтаамжтай.
- Бялт тэслүүрийн удаашралын хугацааг холбогч толгойн өнгөөр ялгасан.
- Удаашралын хугацаа нь нарийвчлал сайтай тул нонель хэрэгсэл тооцсон дарааллын дагуу тэсрэх магадлал 99%-аас дээш байдаг.
- Улаан өнгийн гуурстай үйлдвэрлэгддэг ба энэ нь цооногийн бялт тэслүүрүүдээс хялбар ялгагдах бололцоог олгодог.
- Анхдагч цэнэг нь хамгаалалтын бүрхүүлтэй.

ШИНЖ ЧАНАРУУД

9 өөр хором удаашруулах хугацаатай.

MERA ShockStar SURFACE | ӨДӨӨЛТИЙН СИСТЕМҮҮД

ТЕХНИКИЙН СТАНДАРТ ҮЗҮҮЛЭЛТ

Тэсэлгээний хэрэгсэл	
Хонгионы гадна материал	Хөнгөн цагаан
Хөнгөн цагаан	110 мг
Даралттай усанд тэсвэртэй чанар	0.3 мПа даралтанд 7 өдөр
Ашиглах орчны температурын хязгаар	-30 °C -аас +60 °C
Хадгалах хугацаа болон нөхцөл	2 жил (-30 °C -аас +40 °C, харьцангуй чийгшил 65%) битүүмжилсэн савлагаатай
Шошгоны мэдээлэл	Удаашрал #, Детонаторын төрөл, Удаашрал мс, гуурсын урт, мөшгөх код
Мэдэгдэл хүргүүлсэн байгууллага	CE 0589
Нонель гуурс	
Детонацийн хурд	2,000 ± 100 м/с
Гуурсны өнгө	Улаан

СТАНДАРТ САВЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Нонель гуурсны урт (м)	Савлагаа 1.4S UN 0500		
	Нэгж уутан дахь хэрэгслийн тоо	Нэгж хайрцган дахь уутны тоо	Нэгж хайрцган дахь нийт хэрэгслийн тоо
3.6	10	10	100
4.8	10	8	80
6.0	10	8	80
9	10	6	60
12	5	9	45
15	5	7	35
21	5	6	30
30	5	5	25

MERA ShockStar DUAL DELAY | ӨДӨӨЛТИЙН СИСТЕМҮҮД

ТОДОРХОЙЛОЛТ

ShockStar DUAL DELAY тэсэлгээний хэрэгсэл нь гадаргуугийн холбогч болон цооногийн хэрэгслийг хослуулсан бүтээгдэхүүн юм. Энэхүү хэрэгсэл нь хоёр бүтээгдэхүүн хадгалах зайг хэмнэн, бараа материалын менежментийг хялбар байлгахад тусалдаг ба тээвэрлэхэд шаардлагатай зайг багасгадаг.

ShockStar DUAL DELAY -г хэрэглэснээр гадаргуугийн холболтын тоо багасч, тэсэлгээний холболтын хугацааг хэмнэдэг. Тэслэх цооногуудад хэрэглэгдэх тэсэлгээний хэрэгслийн тоо цөөрснөөр, холболтыг нүдээр шалгахад хялбар болсон.

ДАВУУ ТАЛ

- 720 мг үндсэн цэнэг агуулсан
- Тод шар өнгөтэй үйлдвэрлэгдсэн учир ялгахад хялбар
- Гадаргуугийн холбогч нь 8 гуурсны багтаамжтай ба удаашралын хугацааг өнгөөр ялгасан
- Анхдагч цэнэг нь хамгаалалтын бүрхүүлтэй

ШИНЖ ЧАНАРУУД | ХОРОМ УДААШРАЛЫН ХОСЛОЛ

Номиналь удаашрал (мс)	Shockstar Dual Delay	
	Shockstar Гадаргуугийн	Shockstar MS блон TS
	0	800
	17	475, 500
	25	300, 475, 500
	42, 67	475, 500, 9000
	100, 200	9,000

MERA ShockStar DUAL DELAY | ӨДӨӨЛТИЙН СИСТЕМҮҮД

ТЕХНИКИЙН СТАНДАРТ ҮЗҮҮЛЭЛТ

Тэсэлгээний хэрэгсэл	
Хонгионы материал	Хөнгөн цагаан
Хоёрдогч Өдөөгч тэсрэх бодисын хэмжээ	720 мг / 110 мг
Ус, даралт эсэргүүцэх чадвар	0.3 мПа даралтанд 7 өдөр
Ашиглах орчны температурын хязгаар	-30 °C -аас +60 °C
Хадгалах хугацаа болон нөхцөл	2 жил (-30°C -аас +40°C, харьцангуй чийгшил 65%) битүүмжилсэн савлагаатай
Шошгоны мэдээлэл	Удаашрал #, Детонаторын төрөл, Удаашрал мс, гуурсын урт, Мөшгөх код
Мэдэгдэл хүргүүлсэн байгууллага	CE 0589
Нонель гуурс	
Цочир дамжуулах хурд	2,000 ± 100 м/с
Гуурсны өнгө	Шар

СТАНДАРТ САВЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Нонель гуурсны урт (м)	Савлагаа 1.1B UN 0360			Савлагаа 1.4S UN 0500		
	Нэгж уутан дахь хэрэгслийн тоо	Нэгж хайрцган дахь уутны тоо	Нэгж хайрцган дахь хэрэгслийн тоо	Нэгж уутан дахь хэрэгслийн тоо	Нэгж хайрцган дахь уутны тоо	Нэгж хайрцган дахь хэрэгслийн тоо
6	10	8	80	10	5	50
9	10	6	60	10	4	40
12	5	9	45	10	3	30
15	5	7	35	5	5	25
18	5	6	30	5	4	20
21	5	5	25	5	4	20
24	5	5	25	4	4	16
27	5	5	25	5	3	15
30	5	5	25	3	4	12

MERA ShockStar MS | ӨДӨӨЛТИЙН СИСТЕМҮҮД

ТОДОРХОЙЛОЛТ

ShockStar MS цооногийн тэсэлгээний хэрэгсэл нь 0 мс-аас 1000 мс хүртэл 31 өөр хором удаашралын хугацаатай. Эдгээр хэрэгсэл нь цооног дахь өдөөгч болон тэсрэх бодист цочир өгөх үүрэгтэй.

Цооног дахь удаашруулагч нь Т-холбогчоор дамжуулан цочир дамжуулах шижим эсвэл тэсэлгээний цахилгаан болон цахилгаан бус хэрэгслээс цочир авдаг.

ДАВУУ ТАЛ

- 720 мг үндсэн цэнэг агуулсан.
- Хором удаашруулах хугацаа нь нарийвчлал сайтай бөгөөд цочир авах чадвар нь 99%-иас дээш байна.
- Тод шар өнгөтэй үйлдвэрлэгдсэн учир ялгахад хялбар.
- Анхдагч цэнэг нь хамгаалалтын бүрхүүлтэй.

ШИНЖ ЧАНАРУУД | УДААШРАЛЫН ДАРААЛАЛ

Удаашрал #	**0**	**1**	**2**	**3**	**4**	**5**	**6**	**7**
хугацаа (мс)	0	25	50	75	100	125	150	175
Удаашрал #	**8**	**9**	**10**	**11**	**12**	**13**	**14**	**15**
хугацаа (мс)	200	225	250	275	300	325	350	375
Удаашрал #	**16**	**17**	**18**	**19**	**20**	**21**	**22**	**23**
хугацаа (мс)	400	425	450	475	500	550	600	650
Удаашрал #	**24**	**25**	**26**	**27**	**28**	**29**	**30**	
хугацаа (мс)	700	750	800	850	900	950	1,000	

MERA ShockStar MS | ӨДӨӨЛТИЙН СИСТЕМҮҮД

ТЕХНИКИЙН СТАНДАРТ ҮЗҮҮЛЭЛТ

Тэсэлгээний хэрэгсэл	
Хонгионы материал	Хөнгөн цагаан
Хоёрдогч Өдөөгч тэсрэх бодисын хэмжээ	720 мг / 110 мг
Ус, даралт эсэргүүцэх чадвар	0.3 мПа даралтанд 7 өдөр
Ашиглах орчны температурын хязгаар	-30 °C -аас +60 °C
Хадгалах хугацаа болон нөхцөл	2 жил (-30 °C -аас +40 °C, харьцангуй чийгшил 65%) битүүмжилсэн савлагаатай
Шошгоны мэдээлэл	Удаашрал #, Детонаторын төрөл, Удаашрал мс, гуурсын урт, Мөшгөх код
Мэдэгдэл хүргүүлсэн байгууллага	CE 0589
Нонель гуурс	
Цочир дамжуулах хурд	2,000 ± 100 м/с
Гуурсны өнгө	Шар

СТАНДАРТ САВЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Нонель гуурсны урт (м)	Савлагаа 1.1B UN 0360			Савлагаа 1.4S UN 0500		
	Нэгж уутан дахь хэрэгслийн тоо	Нэгж хайрцган дахь уутны тоо	Нэгж хайрцган дахь хэрэгслийн тоо	Нэгж уутан дахь хэрэгслийн тоо	Нэгж хайрцган дахь уутны тоо	Нэгж хайрцган дахь хэрэгслийн тоо
4.8	10	10	100	20	7	80
6	10	10	100	10	5	70
9	10	8	80	10	4	50
12	10	5	50	10	3	40
15	5	8	40	10	4	30
18	5	7	35	5	4	20
21	5	6	30	5	4	20
24	5	6	30	5	3	20
27	5	5	25	5	4	20
24	5	5	25	3	5	15

MERA ShockStar TS | ӨДӨӨЛТИЙН СИСТЕМҮҮД

ТОДОРХОЙЛОЛТ

ShockStar TS цооногийн тэсэлгээний хэрэгсэл нь 25 мс-аас 9000 мс хүртэл 40 өөр хором удаашруулах хугацаатай. Энэхүү хэрэгслийг газар доорх хонгил, босоо ам болон цооногуудын хооронд урт хугацааны удаашрал шаардлагатай тохиолдолд хэрэглэхэд тохиромжтой байдаг.
Уг бүтээгдэхүүнийг цооног дахь өдөөгч болон тэсрэх бодист өдөөлт өгөх зорилгоор ашигладаг.
Цооног дахь удаашруулагч нь Т-холбогчтой үед цочир дамжуулах шижмээс өдөөлт авч болдог.

ДАВУУ ТАЛ

- 720 мг үндсэн цэнэг агуулсан.
- Хором удаашруулах хугацаа нь нарийвчлал сайтай бөгөөд цочир авах чадвар нь 99%-иас дээш байна.
- Тод шар өнгөтэй үйлдвэрлэгдсэн учир ялгахад хялбар.
- Анхдагч цэнэг нь хамгаалалтын бүрхүүлтэй.

ШИНЖ ЧАНАРУУД | УДААШРАЛЫН ДАРААЛАЛ

Удаашрал #	**0**	**1**	**1 1/2**	**2**	**2 1/2**	**3**	**3 1/2**	**4**
хугацаа (мс)	25	100	150	200	250	300	350	400
Удаашрал #	**4 1/2**	**5**	**5 1/2**	**6**	**6 1/2**	**7**	**7 1/2**	**8**
хугацаа (мс)	450	500	550	600	650	700	750	800
Удаашрал #	**8 1/2**	**9**	**9 1/2**	**10**	**11**	**12**	**14**	**16**
хугацаа (мс)	850	900	950	1,000	1,100	1,200	1,400	1,600
Удаашрал #	**18**	**20**	**25**	**30**	**35**	**40**	**45**	**50**
хугацаа (мс)	1,800	2,000	2,500	3,000	3,500	4,000	4,500	5,000
Удаашрал #	**55**	**60**	**65**	**70**	**75**	**80**	**85**	**90**
хугацаа (мс)	5,500	6,000	6,500	7,000	7,500	8,000	8,500	9,000

MERA ShockStar TS | ӨДӨӨЛТИЙН СИСТЕМҮҮД

ТЕХНИКИЙН СТАНДАРТ ҮЗҮҮЛЭЛТ

Тэсэлгээний хэрэгсэл	
Хонгионы материал	Хөнгөн цагаан
Анхдагч өдөөгч тэсрэх бодисын хэмжээ	720 мг / 110 мг
Ус, даралт эсэргүүцэх чадвар	0.3 мПа даралтанд 7 өдөр
Ашиглах орчны температурын хязгаар	-30 °C -аас +60 °C
Хадгалах хугацаа болон нөхцөл	2 жил (-30 °C -аас +40 °C, харьцангуй чийгшил 65%) битүүмжилсэн савлагаатай
Шошгоны мэдээлэл	Удаашрал #, Бялт тэслүүрийн төрөл, Удаашрал мс, гуурсын урт, мөшгөх код
Мэдэгдэл хүргүүлсэн байгууллага	CE 0589
Нонель гуурс	
Цочир дамжуулах хурд	2,000 ± 100 м/с
Гуурсны өнгө	Шар

СТАНДАРТ САВЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Нонель гуурсны урт (м)	Савлагаа 1.1B UN 0360			Савлагаа 1.4S UN 0500		
	Нэгж уутан дахь хэрэглийн тоо	Нэгж хайрцган дахь уутны тоо	Нэгж хайрцган дахь хэрэглийн тоо	Нэгж уутан дахь хэрэглийн тоо	Нэгж хайрцган дахь уутны тоо	Нэгж хайрцган дахь хэрэглийн тоо
4.8	10	10	100	20	4	80
6.0	10	10	100	10	7	70
7.8	10	8	80	10	5	50

Тэсэлгээний SHOCKSTAR MS хэрэгслийг 385x235x282 мм хэмжээтэй цаасан хайрцагт савлана.
Аустин Детонатор компанид үйлдвэрлэгдсэн энэхүү хэрэгслийг МЕРА ХХК-ийн Т15 үйлдвэрт угсарсан болно.

MERA ShockStar STARTLINE | ӨДӨӨЛТИЙН СИСТЕМҮҮД

ТОДОРХОЙЛОЛТ

ShockStar STARTLINE нь тэсэлгээг эхлүүлэх эсвэл нэг тэсэлгээг нөгөөтэй холбоход ашиглана. Энэхүү бүтээгдэхүүн нь стандарт ShockStar BUNCH CONNECTOR болон дамарт ороосон урт нонель гуурснаас бүтнэ. ShockStar STARTLINE нь нонель гуурс эсвэл 5 граммын агууламжтай цочир дамжуулах шижимд цочрол өгөх зориулалттай. Дамартай гуурсны урт 30 м-ээс 800 м хүрэх бөгөөд холбогч нь ногоон өнгөтэй.

Энэ бүтээгдэхүүнтэй тусгай ажлын журмын дагуу харьцан ажиллана.

ДАВУУ ТАЛ

- Нонель гуурс эсвэл 5 граммын агууламжтай цочир дамжуулах шижимд өдөөлт өгдөг
- Гуурсны улаан өнгөөр нь цооногийн хэрэгслээс ялгахад хялбар
- Анхдагч цэнэг нь хамгаалалтын бүрхүүлтэй

MERA ShockStar STARTLINE | ӨДӨӨЛТИЙН СИСТЕМҮҮД

ТЕХНИКИЙН СТАНДАРТ ҮЗҮҮЛЭЛТ

Тэсэлгээний хэрэгсэл	
Хонгионы материал	Хөнгөн цагаан
Анхдагч өдөөгч тэсрэх бодисын хэмжээ	160 мг
Ус, даралт эсэргүүцэх чадвар	0.3 мПа даралтанд 7 өдөр
Ашиглах орчны температурын хязгаар	-30 °C -аас +60 °C
Хадгалах хугацаа болон нөхцөл	2 жил (-30 °C -аас +40 °C, харьцангуй чийгшил 65%) битүүмжилсэн савлагаатай
Шошгоны мэдээлэл	Удаашрал #, Бялт тэслүүрийн төрөл, Удаашрал мс, гуурсын урт, мөшгөх код
Мэдэгдэл хүргүүлсэн байгууллага	CE 0589
Нонель гуурс	
Цочир дамжуулах хурд	2,000 ± 100 м/с
Гуурсны өнгө	Шар

СТАНДАРТ САВЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Дамартай гуурсны урт (м)	Савлагаа 1.4S UN 0500		
	Нэгж уутан дахь хэрэгслийн тоо	Нэгж хайрцаган дахь уутны тоо	Нэгж хайрцаган дахь нийт хэрэгслийн тоо
50	1	8	8
100	1	8	8
200	1	3	3
500	1	2	2
800	1	1	1

ИМПОРТЫН ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ БОЛОН ТЭСРЭХ БОДИС

MEPA ХХК нь гадаадын томоохон үйлдвэрлэгчдээс тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслүүдийг хэрэглэгчдэд баталгаат чанар, өргөн сонголттойгоор нийлүүж байна.

ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ		
Нэр	**Төрөл**	**Улс**
ДШН	ДШН-6	ОХУ
	ДШН-12	
	ДШН холбогч	
ОШП	ОШП	ОХУ
РП-Д	РП-Д 20мс	ОХУ
	РП-Д 30мс	
	РП-Д 45мс	
	РП-Д 60мс	
	РП-Д 80мс	
	РП-Д 100мс	
Цооногийн Искра-С	Искра-С 500 мс-6м	ОХУ
	Искра-С 500 мс-9м	
	Искра-С 500 мс-12м	
	Искра-С 500 мс-15м	
	Искра-С 500 мс-18м	
	Искра-С 500мс 25м	
	Искра-С-500мс-40м	
	Искра-С 500 мс-50м	
Гадаргуугийн Искра-П 6м	Искра-П 17 мс-6м	ОХУ
	Искра-П 25 мс-6м	
	Искра-П 42 мс-6м	
	Искра-П 55мс 6м	
	Искра-П 67 мс-6м	
	Искра-П 109 мс-6м	
Гадаргуугийн Искра-П 9м	Искра-П-25мс-9м	ОХУ
	Искра-П-42мс-9м	
	Искра-П-67мс-9м	
	Искра-П-109мс-9м	

Гадаргуугийн Искра-П 12м	Искра-П-17мс-12м	ОХУ
	Искра-П-25мс-12м	
	Искра-П-42мс-12м	
	Искра-П-55мс-12м	
	Искра-П-67мс-12м	
	Искра-П-109мс-12м	
	Искра-Ш-500мс-12м	
Далдын Искра-Ш 4м	Искра-Ш-50мс-4м	ОХУ
	Искра-Ш-200мс-4м	
	Искра-Ш-600мс-4м	
	Искра-Ш-1000мс-4м	
	Искра-Ш-1500мс-4м	
	Искра-Ш-2000мс-4м	
	Искра-Ш-3000мс-4м	
	Искра-Ш-4000мс-4м	
Далдын Искра-Ш 12м	Искра-Ш-12м-500мс	ОХУ
УВТ	УВТ	ОХУ
Хавчаар	Хавчаар ИВШП	ОХУ
	Хавчаар хуучин цагаан	

өдөөгч

Нэр	**Төрөл**	**Улс**
Өдөөгч /Импорт/	Өдөөгч 300 гр	ОХУ
	Өдөөгч 400 гр	
	Өдөөгч 750 гр	

ҮЙЛЧИЛГЭЭ

- ТЭСЭЛГЭЭНИЙ ЦООНОГ ӨРӨМДӨХ ҮЙЛЧИЛГЭЭ
- ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ
- ЦООНОГ ЦЭНЭГЛЭХ БОЛОН ТҮГЖИХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ
- ТЭСРЭХ МАТЕРИАЛЫН ТЭЭВЭРЛЭЛТ
- ТЭСРЭХ МАТЕРИАЛ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

ТЭСЭЛГЭЭНИЙ ЦООНОГ ӨРӨМДЛӨГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

MEPA компани нь өрөмдлөгийн үйлчилгээ үзүүлэгчид дотроос хамгийн өндөр бүтээмжтэй компанитай бөгөөд тэсэлгээний цооног өрөмдөх тусгай зориулалтын өрөм болох өндөр бүтээлтэй, найдвартай ажиллагаагаар тэргүүлэгч Epiroc/Atlas Copco/ фирмийн DM45, FlexiRoc D65, PV-275D, Япон улсын “Фурукава Рок Дрилл” фирмийн HCR 1500 – ED II, болон PCR-DTH зэрэг өрмийн машин техникээр 115-229 мм-ийн диаметртэй, 53 метр хүртэл гүнтэй тэсэлгээний цооногийн өрөмдлөгийг уурхайн онцлог, захиалагчийн хэрэгцээ шаардлагыг дагуу хамгийн оновчтой шийдлээр хийж гүйцэтгэж байна.

Манай өрмүүд нь усан систем, камерын систем, хяналтын систем, цооногийн гүн болон чулуулгийн хатуулаг хэмжин мэдээллэдэг төхөөрөмжөөр тоноглогдсон учир өрөмдлөгийн хамгийн оновчтой шийдлийг тооцоолон гаргахад чухал ач холбогдолтой юм. Бид гүйцэтгэлийнхээ үр дүнг өндөр байлгах үүднээс өөрсдийн техник тоног төхөөрөмжид байнгын шинэчлэлт, сайжруулалтуудыг хийж, салбартаа тэргүүлэгч дэлхийн шилдэг технологиудыг ашиглаж байна.

ӨРМИЙН ТЕХНИКИЙН ХҮЧИН ЧАДАЛ:

- Atlas Copco DM45HP – Цооногийн диаметр 171-229мм, АНУ улсад үйлдвэрлэгдсэн (5 ширхэг)
- Atlas Copco DM45LP – Цооногийн диаметр 171-229мм, Швед улсад үйлдвэрлэгдсэн (1 ширхэг)
- Atlas Copco FlexiROC D65 – Цооногийн диаметр 115-229мм, Швед улсад үйлдвэрлэгдсэн (2 ширхэг)
- Atlas Copco PV-275D – Цооногийн диаметр 193-270мм, АНУ (2 ширхэг)
- Furukawa HRC 1500 – ED II – Цооногийн диаметр 127мм, Япон улсад үйлдвэрлэгдсэн (4 ширхэг)
- Furukawa PCR-DTH – Цооногийн диаметр 127мм, Япон улсад үйлдвэрлэгдсэн (1ширхэг)

ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Манай компани нь олон улсад өргөн ашиглагдаж байгаа сүүлийн үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, технологи, програм хангамж хослуулан ашиглаж инженерчлэлийн нарийн тооцоотойгоор, захиалагчийн хүсэлтийн дагуу уурхайн онцлогт тохируулан, аюулгүй ажиллагааг эрхэмлэн, дэвшилтэт тоног төхөөрөмж ашиглан тэсэлгээний ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд хурдан шуурхай хийж гүйцэтгэдэг. Томоохон уул уурхайн хөрс хуулалтын тэсэлгээ, нүүрсний тэсэлгээ, хайрганы тэсэлгээ, замын транс гаргах тэсэлгээ, далд уурхайн тэсэлгээ болон нарийн технологи шаардсан хүдрийн судал ялгах тэсэлгээ, нүүрсний 2-3 давхаргыг ялгах тэсэлгээ, уурхайн хананы гулсалт зогсоох “Buffer” тэсэлгээ, уурхайн эцсийн хана үлдээх “presplit” тэсэлгээг зураг паспортын дагуу алсаас тэслэх багаж ашиглан чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэж байна. Мөн цооногийн ус соруулж “Liner” уут хэрэглэх, агаарын зай үүсгэгч уут “Gas bag” ашиглан тэсэлгээний ажлын зардал бууруулах, тэсэлгээний чанар, үр ашгийг нэмэгдүүлэн, чичирхийлэл болон дундаж бутлагдал хэмжих багаж ашиглан тэсэлгээний ажлын үр дүнг тодорхойлон хэрэглэгчидэд тэсэлгээний ажил үйлчилгээний талаар үнэн бодит мэдээллийг цаг тухайд нь хүргэхийн чацуу өөрсдийн ажил үйлчилгээнд үнэлгээ дүгнэлт хийн тасралтгүй сайжруулах бодлого баримтлан ажиллаж байна.

ТЭСЭЛГЭЭНИЙ ЦООНОГ ЦЭНЭГЛЭХ, ТҮГЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ

МЕРА ХХК нь ил болон далд уурхайд тэсэлгээний цооног цэнэглэх бүрэн чадавхтай. МЕРА ХХК нь эмульсийн болон энгийн тэсрэх бодис үйлдвэрлэн, сүүлийн үеийн дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж, байршил тогтоогч GPS-ээр тоноглогдсон цооног цэнэглэгч Sterling, Western Star, Scania, Volvo, Faw маркын автомашинуудаар тэсэлгээний цооног цэнэглэх, түгжих үйлчилгээг үзүүлэн ажилаж байна. Эдгээр автомашинууд нь тэсрэх бодисын түүхий эдийг цооногт шахах үед тэсрэх бодис болон үйлдвэрлэгддэг тул аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан шийдэлтэй хөдөлмөр хамгааллын зардлыг хэмнэх, бүтээмжийг нэмэгдүүлэн, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдгээрээ хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд хэдийн танигдаж чадсан билээ.

ТЭСРЭХ БОДИС ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Тэсрэх бодис тээвэрлэх үйлчилгээгээр харилцагчдаа хангах, эрсдлийг бууруулах, өртөгийг бууруулах зорилгоор манай компани тэсрэх бодис тээвэрлэн хүргэх үйлчилгээг бизнестээ нэвтрүүлэн ажиллаж байна. Бид тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэхдээ стандартын шаардлага хангасан, GPS, сансрын хөдөлгөөнт утас, тэсрэх бодистой харилцах эрхтэй мэргэшсэн жолооч, тэсрэх бодистой харилцах эрхтэй тээвэр хариуцагч бүхий тусгайлан бүрэн тоноглогдсон, битүүмжилсэн тээврийн хэрэгслээр, аюул осолгүй, түргэн шуурхай, найдвартай тээвэрлэн хүргэж байна. Бид түүхэн хугацаанд онцгой болон аюултай ачааг аюул осолгүй тээвэрлэх логистикийн менежментийг бий болгож чадсан бөгөөд хамгийн найдвартай, мэргэжлийн үйлчилгээг цаг тухайд нь хүргэн ажиллах бүрэн чадвартай.

ТЭСРЭХ МАТЕРИАЛ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Бид тэсэлгээний ажил үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэсрэх бодисын түүхий эдийг хадгалах үйлчилгээ үзүүлж байна. Тэсрэх материал хадгалах агуулахууд нь “Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн шаардлагыг бүрэн хангасан, тусгай харуул хамгаалалт бүхий 2587м2 талбай бүхий 5 агуулахтай